



Улсын Статистик 9

# СТАТИСТИК ТООН МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГЛЭЭ, АЧ ХОЛБОГДОЛ



# СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЭЛ



## Статистикийн шинэчлэлийн хөтөлбөр

- Улс орнууд болон олон улсын статистикийн байгууллагын удирдлагууд оролцсон дээд хэмжээний зөвлөлдөх уулзалт 2015 онд болж, Статистикийн шинэчлэлийн хөтөлбөр"-ийг батлан гаргасан.
- Хөтөлбөрийг үндсэн 5 чиглэлээр хэрэгжүүлэхээр болсон.

### Мэдээллийн хувьсгал

- Шинэ технологийг нэвтрүүлэх, ашиглах
- Уламжлалт бус мэдээллийн эх үүсвэрийг ашиглах
- **Статистикийн мэдээллийн бусад үйлдвэрлэгчидтэй хийх өрсөлдөөн**

### Шинэ хэмжигдэхүүн

- Даяаршилтай шинэ холбоотой шинэ мэдээлэл бий болгох
- ЭЗ, нийгмийн байдлыг бодитоор харуулах
- Газар зүйн байршлаарх дэлгэрэнгүй мэдээлэл

### Статистикийг үнэ цэнэтэй болгох

- **Статистикийн чанарыг сайжруулж, брэнд болгох**
- Төсвийг багасгах, үр ашигтай зарцуулах
- Мэдээлэгчдэд учруулах дарамтыг багасгах

### Нийгэмд үүссэн эрэлт, хэрэгцээ

- Хэрэглэгчдийг хэрэгцээ, шаардлагын дагуу бүлэглэх
- ТХЗ-ийн хэрэгжилтийг гаргах, дүгнэх
- Цаг хугацаандаа, шуурхай байх

# “Шинэчлэлийн хөтөлбөр”-ийн үндсэн 5 чиглэл



- 1** Уялдуулан зохицуулах-Дэлхий, бүс, үндэсний түвшин дэх статистикийн системийн хоорондох уялдаа холбоог сайжруулах
- 2** Харилцан холбоотой байх-Харилцаа холбоотой байж, сурталчилгааг сайжруулах
- 3** Нэгдмэл зохион байгуулалтад оруулах - Статистикийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, тархаах үйл ажиллагааг нэгдмэл байдлаар зохион байгуулах
- 4** Шинэчлэлт, өөрчлөлт хийх-Статистикийн үйл ажиллагааны стандарт загварт суурилж, статистикийн шинэчлэл, инновацийг хэрэгжүүлэх
- 5** Статистикийн чадавхийг бэхжүүлэх-Статистикийн чадавхийг бэхжүүлэх, сургах



МОНГОЛЫН  
УЛСЫН  
СТАТИСТИК  
ТӨВӨН



# СУДАЛГААНЫ АЖИЛ ГЭЖ ЮУ ВЭ



МОНГОЛЫН УНДСНИМ СТАТИСТИК

## Судалгааны ажил нь:

- ❖ Тухайн судалж байгаа үзэгдлийн өөрчлөлтийн зүй тогтлыг түүнд нөлөөлөх хүчин зүйлсээр илэрхийлэх
- ❖ Чиг хандлагыг тодорхойлж, дүгнэлт, зөвлөмж гаргах зорилго бүхий үйл ажиллагаа юм.

## Судалгааны ажлын үндсэн зарчим:

- ❖ Үнэн зөв, нарийн дэс дараалалтай байх
- ❖ Судалгааны үр дүн баталгаажсан, шинжлэх ухааны үндэслэлтэй байх
- ❖ Хэл, найруулгын хувьд ойлгомжтой, дүгнэлт зөвлөмж нь үндэслэлтэй байх



# СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮЕ ШАТУУД



МОНГОЛЫН  
УЛСЫН  
СТАТИСТИК  
ТӨВӨН

1. Судалгаа хийх асуудлын талаар судлах, тодорхойлох

2. Судалгаа хийх асуудлын талаар ижил төстэй, холбоотой байж болох материалыг уншиж судлах

3. Судалгааны аргачлал, арга тодорхойлох арга зүйг

4. Судалгааны ажлыг гүйцэтгэх

5. Тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийх

6. Судалгааны ажлын үр дүнг тайлагнах, тайлан боловсруулах

**Үр дүнг тайлагнах, тайлан боловсруулах зорилго:**

“Судалгааны ажлын талаарх эмх, цэгцтэй мэдээллийг бусдад мэдлэг болгон түгээх”

# СУДАЛГААНЫ ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ



Танилцуулга, шинжилгээ судалгааны ажил нь:

## 1. Өмнөх хэсэг

- Үндсэн гарчиг
- Өмнөх үг буюу талархал
- Хураангуй
- Агуулга
- Графикийн жагсаалт
- Хүснэгтийн жагсаалт
- Товчилсон үг, тэмдэглэгээний жагсаалт

## 2. Үндсэн хэсэг

- Удиртгал/танилцуулга
- Тухайн сэдэвтэй холбогдох шинжилгээ судалгааны ажлын тойм
- Онол, арга зүй болон тоо мэдээлэл
- Үр дүн
- Дүгнэлт/ санал, зөвлөмж

## 3. Төгсгөл хэсэг

- Ашигласан материал, номын жагсаалт
- Хавсралт
- Нэр томъёоны тайлбар



## 1. Судалгааны өмнөх хэсэг

**Үндсэн гарчиг:** тухайн шинжилгээ судалгааны ажлын гол зорилгыг агуулсан сэдвийн нэр байна.

**Өмнөх үг буюу талархал:** тухайн шинжилгээ судалгааны ажлыг хийхэд тусалж дэмжсэн байгууллага, хамт олон, хувь хүнд илэрхийлсэн талархал

**Хураангуй:** судалгааны сэдэв, цар хүрээ, зорилго; ашигласан арга зүй; үр дүн; зөвлөмж зэрэг судалгааны тайлангийн үндсэн хэсэг

Хураангуйн доор түлхүүр үгсийг бичих бөгөөд тухайн шинжилгээ судалгааны ажилд олон давтагдсан, гол утга агуулгыг илэрхийлсэн 5-7 үг

**Агуулга:** тухайн шинжилгээ судалгааны ажлын бүтцийн үндсэн болон дэд гарчигууд

**Графикийн жагсаалт:** тухайн шинжилгээ судалгааны ажилд тусгасан дүрслэл, графикуудын нэр, дугаар

**Хүснэгтийн жагсаалт:** тухайн шинжилгээ судалгааны ажилд байгаа хүснэгтүүдийн нэр, дугаар

**Товчилсон үг, тэмдгийн жагсаалт:** тухайн шинжилгээ судалгааны ажилд хэрэглэсэн товчилсон үг, тэмдэгтүүдийг бүтэн үгээр нь тухайн товчилсон үсгүүдийн тайлбар



## 2. Судалгааны үндсэн хэсэг

**Удиртгал/танилцуулга:** тухайн шинжилгээ судалгааны ажлын зориулалт болон судалгааны ажлын зорилго, зорилт, судалж буй асуудлын талаарх ерөнхий танилцуулга, ач холбогдол, холбогдох тоо баримт, дэвшүүлж байгаа таамаглалууд

**Холбогдох шинжилгээ, судалгааны ажлын тойм:** тухайн сэдвийн талаарх шинжилгээ судалгааны хөгжилд бусад судлаачдын оруулсан хувь нэмэр, эдгээр шинжилгээ судалгааны ажлуудын талаарх (зохиогчийн болон бүтээлийн нэрийг заавал тавина) товч тайлбар, үнэлгээ, харьцуулалт, тухайн сэдвээр судлаачдын нийтээрээ хүлээн зөвшөөрч буй болон санал нийлэхгүй байгаа асуудлууд

**Онол, арга зүй, тоо мэдээллийн хэсэг:** тухайн шинжилгээ судалгааны ажилд ашигласан тоо баримтын эх үүсвэр болон тодорхойлолт; хамрах хүрээ, хамрагдсан хугацаа; онолын томъёолол, дэвшүүлсэн таамаглал, ашигласан эконометриксийн арга, загвар, загварчлал, статистикийн шинжилгээний аргуудын тайлбар

**Үр дүн хэсэгт тухайн шинжилгээ:** судалгааны ажлын гол үр дүн, ололтыг тусгана. Гол үр дүн, ололтод ямар нэг тайлбар, үнэлгээгүйгээр статистикийн болон эконометриксийн дүн шинжилгээний үр дүнг тусгах бөгөөд график, хүснэгт болон үгчилсэн тайлбар, загвар, дүн шинжилгээний үр дүн





## 2. Судалгааны үндсэн хэсэг

**Дүгнэлт болон бодлогын санал, зөвлөмж хэсэгт:**

- 1.Гол үр дүнгүүдийн үнэлгээ дүгнэлт, тайлбар;
- 2.Тухайн судалгааны урьдчилсан төсөөлөл, таамаглалыг тэдгээр үр дүн нотолж, эсвэл үл нотолж байгаа эсэхийн тайлбар;
- 3.Тухайн шинжилгээний үр дүнг холбогдох бусад судалгаа, шинжилгээний ажил, ном зүйн материал дахь үр дүнтэй уялдуулсан болон харьцуулсан дүгнэлт
- 4.Гарсан үр дүнг ашиглан тухайн асуудал, сэдвийн талаарх ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх, холбогдох онолын хөгжилд ахиц гаргах дүгнэлт;
- 5.Бодлогын зөвлөмж, хэрэгжүүлэх арга хэмжээний санал;
- 6.Шинжилгээ судалгааны ажилд тулгарсан хүндрэл, тавигдсан хязгаарлалт зэргийг дурьдана

## 3. Судалгааны төгсгөл хэсэг

**Ашигласан материал, номын жагсаалт:** тухайн шинжилгээ судалгааны ажилд ашигласан эх үүсвэрүүд

Ашигласан материал, номын жагсаалтыг зохиогчийн нэрсийн цагаан толгойн дарааллаар нь бүтээлийнх нь нэр, он, тухайн бүтээлийг хэвлэсэн сэтгүүл, номын нэр, дугаарыг тухайн бүтээлийн хэвлэгдсэн хуудасны дугаартай нь тавина.

**Хавсралт хэсэгт:** тухайн шинжилгээ судалгааны ажилд ашигласан тоо мэдээллийн динамик, эконометр, статистикийн шинжилгээний үр дүнгүүдийн хүснэгтүүдийг хавсаргана.


**Нэр томъёоны тайлбарт:** тухайн шинжилгээ судалгааны ажилд ашигласан нэр, томъёоны тодорхойлолт, тайлбарыг тусгана.




# СУДАЛГАА, ТАНИЛЦУУЛГА БЭЛТГЭХЭД АНХААРАХ ЗҮЙЛС

## Статистикийн бүтээгдэхүүнүүд

- ❖ Сарын мэдээний танилцуулга, бюллетень
- ❖ Сэдэвчилсэн судалгааны тайлангууд
- ❖ Жилийн эмхэтгэл
- ❖ Динамик сан, мэдээллийн нэгдсэн сан
- ❖ Инфографик
- ❖ Товхимол, боршур
- ❖ Цахим мэдээллүүд



- ❖ Текст мэдээлэл
- ❖ Хүснэгт
- ❖ График
- ❖ Зурган дүрслэл



- ❖ MS Word
- ❖ MS Excel
- ❖ In design



МОНГОЛЫН  
УЛСЫН  
СТАТИСТИК  
ТӨВРӨГ



## СУДАЛГАА, ТАНИЛЦУУЛГА БЭЛТГЭХЭД АНХААРАХ ЗҮЙЛС

❖ Хувь хүн, хуулийн этгээдийн мэдээллийн нууцлалыг чандлан хадгална.

**Статистикийн тухай хуулийн 22 зүйлийн 6 заалт:** “Статистикийн төв, орон нутгийн байгууллага нь хувь хүн, хуулийн этгээдийн мэдээллийн нууцыг чанд хадгалж, мэдээллийг улс, бүс нутаг, аймаг, нийслэл, сум, дүүрэг, салбарын түвшинд нэгдсэн дүн гаргах, статистикийн үзүүлэлтийг тооцоход ашиглана”

❖ “Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдлын сар, улирлын бюллетень, танилцуулгыг бэлтгэхэд баримтлах нэгдсэн заавар”-ыг баримтална.

**Нийтлэг үндэслэл:** Энэхүү зааврыг “Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал” статистикийн сар, улирлын бюллетень болон танилцуулгыг бэлтгэхэд салбарын хэмжээнд мөрдлөг болгон ашиглана.

*(ҮСХ-ны даргын 2017.2.6 А/14 тоот тушаал)*

<http://web.nso.mn/AAZMS/web/detail/57>



## СУДАЛГАА, ТАНИЛЦУУЛГА БЭЛТГЭХЭД АНХААРАХ ЗҮЙЛС

- Нэгдсэн стандартын дагуу салбаруудын мэдээллийг бэлтгэх
- Хүснэгт, графикийн нэрийг оновчтой өгөх;
- Тухайн үзүүлэлтийн ерөнхий хандлага, дүр зургийг тодорхойлох, цөөн үзүүлэлтээр энгийн харьцуулалт хийхээр графикийн төрлийн оновчтой сонгох
- Графикт 3D хэмжээст графикаас татгалзах
- Хүснэгт, графикт тусгагдсан үзүүлэлтүүдийн хамрах хугацаа, хэмжих нэгжийг тодорхой заах
- График, хүснэгтийн аль илэрхийлэх тохиромжтойг сонгох
- Шаардлагатай тохиолдолд үзүүлэлтийг тооцсон аргачлалыг томъёолох
- Ашигласан тэмдэглэгээг тайлбарлах;
- Мэдээллийн эх үүсвэрийг дурдах



МОНГОЛЫН ҮНДСНИЙ СТАТИСТИК



# СУДАЛГАА, ТАНИЛЦУУЛГА БЭЛТГЭХЭД АНХААРАХ ЗҮЙЛС



МОНГОЛЫН УЛСЫН СТАТИСТИК

## Сүргийн бүтэц, малын төрлөөр

	1980	1985	1990	1995	2000*	2002	2003**
Адуу	12.81	14.01	13.91	13.85	14.28	14.19	14.65
Үхэр	15.21	16.01	15.91	14.54	15.65	15.38	15.17
Тэмээ	1.34	1.38	1.82	1.56	1.59	1.62	1.65
Хонь	35.88	34.68	33.48	35.76	34.83	34.66	35.12
Ямаа	34.76	33.92	34.88	34.29	33.65	34.15	33.41
Нийт	100	100	100	100	100	100	100

## Сүргийн бүтэц, малын төрлөөр, хувь

	1980	1985	1990	1995	2000	2002	2003*
Адуу	12.8	14.0	13.9	13.9	14.3	14.2	14.7
Үхэр	15.2	16.0	15.9	14.5	15.7	15.4	15.2
Тэмээ	1.3	1.4	1.8	1.6	1.6	1.6	1.7
Хонь	35.9	34.7	33.5	35.8	34.8	34.7	35.1
Ямаа	34.8	33.9	34.9	34.3	33.7	34.2	33.4
Нийт	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0

Тайлбар: \* Мал тооллогын урьдчилсан дүн  
 Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан

- Ямар нутаг дэвсгэрийн мэдээллийг илтгэж байгаа нь тодорхойгүй
- Мэдээллийн эх үүсвэрийг заагаагүй
- Хүснэгтийн нүдэнд тоог баруун талд нь бус, голлуулж байрлуулсан
- Тоон утгыг таслалын ард хоёр оронгоор илэрхийлэх шаардлагагүй
- Дүн буюу "Бүгд" утгыг бусад утгатай ижилхэн оронгоор илэрхийлээгүй
- " \* , \*\* " гэсэн тэмдэглэгээг тайлбарлаагүй
- Зарим мөрийг саарал өнгөөр ялгаж, нүд болгоныг хар зураасаар хүрээлсэн нь мэдээллийг уншихад төвөгтэй болгосон



# СУДАЛГАА, ТАНИЛЦУУЛГА БЭЛТГЭХЭД АНХААРАХ ЗҮЙЛС




МОНГОЛ УЛСЫН  
УНДСНИЙ  
СТАТИСТИК



Импортын бүтэц, орноор,  
Монгол улс, 2010




Импортын бүтэц, орноор,  
хувиар, Монгол улс, 2010




Эх үүсвэр: ҮСХ, Статистикийн эмхтгэл, 2010



Төвөгтэй график



Ойлгомжтой график



www.nso.mn





Улсын Статистик 9

# АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА